

**“БАГАЧУУД ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Сүүрв түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн ХУВь
<p><b>БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО 1. “Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.</b></p>							
<p><b>ЗОРИЛТ 1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. НЭДҮАХ 1.1.1.</b></p>							
1.1	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажиллах	Төсөв шаардахгүй	тоо	17	17	Цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсруулсан төлөвлөгөөний дагуу ажлын байранд халдвар хамгааллын дэглэм баримтлан, нийт ажилчдад маск, гар ариутгагчийг тогтмол хэрэглэдэг. Байгууллагын контор болон агуулах, түгээлтийн тээврийн хэрэгслүүдийг ариутгах халдваргүйжүүлэлийг улирал бүр тогтмол хийж ажиллаж байна.	100%
1.2	Байгууллагын контор, махны болон хуурай хүнсний агуулахууд, хүнсний зориулалттай түгээлтийн автомашинуудыг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах;	Батлагдсан төсвийн хүрээнд	Ариутгал хийгдсэн тоо	2	3	“САН ХИМИ” ХХК-тай гэрээ байгуулсаны дагуу 2023 онд 4 удаа оффис, махны болон хуурай хүнсний агуулах, хүнсний зориулалттай 2 автомашины халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийлгэж, нийт 605.000,00 төгрөг зарцуулсан байна.	100%
1.3	Байгууллагын гадна, доторх талбайн их цэвэрлэгээг хийх;	Төсөв шаардахгүй	Цэвэрлэгээ хийсэн тоо	7 хон огт 1	2	Хүнсний агуулахад 7 хоног бүрийн Мягмар, Баасан гарагт тогтмол цэвэрлэгээ хийдэг ба сард 1 удаа гадна талбайн цэвэрлэгээг хийж ажиллалаа. Нийт хүнсний агуулахад 80 удаа, гадна талбайн цэвэрлэгээг 10 удаа хийсэн.	100%

1.4	Ажилчдын хөдөлмөр, хамгааллын хувцас, нэг удаагийн халдвар хамгааллын хэрэгсэл, гар ариутгагч, амны хаалгаар тогтмол хангаж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллах;	Батлагдсан төсвийн хүрээнд	хувь	100	100	Түгээлтэнд явж буй ажилчид болон оффисын ажилчдад маск, гар ариутгагчаар бүрэн ханган ажилладаг. Түгээлтийн ажилчдын мах, хуурай хүнсний хувцас, гутал хэрэглэлд нийт 2.961.000.00 төгрөгийг зарцуулсан байна.	100%
<b>БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО 2. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн, сурцалцагчийн хөгжлийг дэмжсэн “Нийслэлийн боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>							
<b>ЗОРИЛТ 1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол, хүнсээр хангана. НЗДҮАХ 2.3.5.2.</b>							
2.1.1	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлэх хүнсний бараа, бүтээгдэхүүний онлайн захиалгыг боловсронгуй болгож, цэцэрлэг, сургуулийг онлайн захиалгыг нэмэгдүүлэн хяналт тавьж ажиллах;	Төсөв шаардахгүй	7 хоногийн захиалгын тоо	2	2	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлэх хүнсний бараа, бүтээгдэхүүний онлайн захиалгын цэсийг тогтмол шинэчлэн, сургууль, цэцэрлэг онлайн аргаар захиалгаа өгөх талаар 2 удаа сургалт орсноор онлайн аргаар захиалгаа өгөх цэцэрлэг, сургуулийн тоо өссөн.	100%
<b>ЗОРИЛТ 2. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ. НЗДҮАХ 3.1.4.5</b>							
2.2.1	2023 оны нийт худалдан авалтын үнийн дүнгийн 50-иас дээш хувьд дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн худалдан авах	Төсөв шаардахгүй	Нийт худалдан авалт	5	5	2023 оны жилийн эцсийн байдлаар үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нийт худалдан авалтын нэр төрлөөр 35 хувь, үнийн дүнгээр 50,1 хувиас дээш хувийг эзэлж байна.	100%
<b>ЗОРИЛТ 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд /дүрмээр хүлээсэн чиг орно/</b>							
3.1	УИХ, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамж, дээд газрын үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах;	Төсөв шаардахгүй	Тогтоол, шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийн үр дүн, хувь	100	100	Засгийн газрын тогтоол, Нийслэлийн онцгой комиссын шийдвэр, Нийслэлийн засаг даргын захирамж, нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100%
3.2	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчийн, сургууль цэцэрлэгүүдтэй “Бүтээгдэхүүн	Төсөв шаардахгүй	Чанар стандартын шаардлагад	82	86	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийт 73 цэцэрлэг, ерөнхий боловсролын 13 сургуультай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу чанар,	100%

	<p>нийлүүлэх гэрээ" байгуулан ажиллах, чанар, стандартын шаардлагад нийцсэн, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган ажиллах;</p>		<p>нийцсэн, эрүүл хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тоо</p>			<p>стандартын шаардлагад нийцсэн 119 нэр төрлийн эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган ажиллаж байна.</p>	
3.3	<p>Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас нийлүүлэгдэж буй хүнсний бараа, бүтээгдэхүүнийг мэргэжлийн байгууллагаас гаргасан шинжилгээний бичиг, гарал үүслийн бичгийг үндэслэн татан авч, цэцэрлэгүүдэд нийлүүлэх;</p>	<p>Төсөв шаардахгүй</p>	<p>Барааны нэр төрөл</p>	<p>100</p>	<p>110</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйг сахин хамгаалахын үндсэн дээр бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа тогтмол мэргэжлийн байгууллагын эрүүл ахуйн дүгнэлт, шинжилгээний бичиг, гарал үүслийн бичиг, үйлдвэрлэсэн хугацаа, хадгалалт, сав баглаа боодлыг шалган хүлээн авч, цэцэрлэг, сургуулиудад түгээн ажиллаж байна. Мах, махан бүтээгдэхүүн, нарийн, бүүдүүн ногооны шинжилгээний бичгийг сард 1 удаа, бусад нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний шинжилгээний бичгийг 12 сард 1 удаа хянан шалгаж, бүртгэлжүүлэн ангилан хадгалдаг.</p>	100%
3.4	<p>Цэцэрлэг сургуулийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан түгээлт хийх автомашины хүрэлцээ муу байгаа учир хүнсний зориулалтын түгээлтийн автомашин худалдан авах;</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>Машины тоо</p>	<p>100</p>	<p>100</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд нээлттэй тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаж оролцогч шалгараагүй тул дахин тендерийг зарласан. 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр тендерийн нээлт хийж, 3 аж ахуй нэгж байгууллага тендерийн материал ирүүлсэн бөгөөд оролцогч шалгараагүй учир тендерийн үнэлгээний хорооноос шууд худалдан авалт хийхийг байгууллагын удирдлагад зөвлөмж хүргүүлсэний дагуу 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Автомашин худалдах, худалдан авах гэрээг "Хан ажнай" ХХК-тай байгуулан 2015 онд үйлдвэрлэсэн "Huundai Mighty" маркийн тусгай зориулалтын +-30 градусын хөргүүртэй түгээлтийн автомашиныг 75.000.000,00 төгрөгөөр худалдан авсан.</p>	100%
3.5	<p>Контор, агуулахын барилгын ашиглалт, элэгдэлийг бууруулах зорилгоор урсгал засвар хийх;</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>100</p>	<p>100</p>	<p>Байгууллагын ашиг орлогоос шалтгаалж контор, агуулахын барилгын ашиглалт, элэгдэлийг бууруулах зорилгоор 1 өрөөнд урсгал засвар хийж 1,530,000.00 төгрөг зарцуулан ажилласан байна.</p>	100%

3.6	Өмч хөрөнгийн хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг явуулах;	Төсөв шаардахгүй	Эд хөрөнгийн тооллогын бүртгэл, тоо	2	2	Багачууд Хүнс ОНӨААТҮГ-ийн бараа материалын дансанд бүртгэлтэй урагдаж цоорсон ажлын гутал хувцас, будаа агшаагч болон цаашид ашиглагдах боломжгүй болсон бусад бага үнэтэй бараа материалыг 2,363,636.34 төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлаж устгасан.	100%
3.7	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж, үргүй зардлыг хэмнэх;	Төсөв шаардахгүй	Санхүүгийн сахилга батын хэрэгжилт, хувь	100	100	<p>2023 онд дараах зардлуудыг хэмнэн ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоод албан томилолтын зардалд 9,000.0 мянган төгрөг төсөвлөснөөс 100 хувь хэмнэж ажилласан. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээнд цахим хэлбэрээр оролцсон ба байгууллага дээрх сургалтыг өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан ямар нэгэн зардал гаргалгүйгээр зохион байгуулж ажилласан.</li> <li>- Цалингийн зардал нь 452,987.32 мянган төгрөг төлөвлөснөөс 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 192,090.25 мянган төгрөг буюу 260 гаруй сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.</li> <li>- Гэрэл цахилгааны зардлыг 63,816.00 мянган төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 41,015.00 мянган төгрөг буюу 22,801.00 мянган төгрөгийн хэмнэлтийг гарган ажиллалаа.</li> </ul>	100%
3.8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан, мэдээ гаргах, архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэх, хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх;	Төсөв шаардахгүй	Албан бичгийн тоо	100	100	2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 121 албан бичиг ирснээс хариутай бичиг 41, хариугүй 80 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 149 албан бичиг явуулсан байна. Хугацаа хэтэрсэн 1 албан бичиг байна.	100%
3.9	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр шинэчлэх;	Төсөв шаардахгүй	Нийт боловсруулагдсан дүрэм, журмын тоо	100	100	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам, хог хаягдал зайлуулах журмыг шинэчлэн батлуулж	100%

						гэрээний заалт, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн, зөрчил гаргалгүй ажиллуулж байна.			
3.10	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын <a href="http://www.egr.ulaanbaatar.mn">www.egr.ulaanbaatar.mn</a> , цахим хуудсыг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглах;	Төсөв шаардахгүй	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын ажилчид өдөр тутмын үйл ажиллагаандаа <a href="http://www.egr.ulaanbaatar.mn">www.egr.ulaanbaatar.mn</a> , цахим хуудсыг тогтмол ашиглаж байна.	100%		
3.11	Хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавих, аюулаас урьдчилан сэргийлэх, чанаржуулах ажлыг зохион байгуулах;	Төсөв шаардахгүй	Нийт өгсөн аюулгүй ажиллагааны зааварчилгаа тоо	100	100	Ажилтан, албан хаагчдад өдөр бүр хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж, ажлын гутал хувцас, автомашины аюулгүй байдлыг тогтмол шалган ажиллаж байна. Мөн энэ хугацаанд ажлын байрны осол, хөдөлмөрийн аюулгүй байдал зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.	100%		
3.12	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Төсөв шаардахгүй	Хуулийн хэрэгжилт, хувь	100	100	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар нөлөөллийн 5 ажлыг ажилтнууддаа зохион байгуулсан. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 7 сургууль, 56 цэцэрлэгийн нярвуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулж ажилласан.	100%		
3.13	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах;	Батлагдсан төсвийн хүрээнд	Жилийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт, хувь	9	12	Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ажилтнуудын цалинг шинэчлэн тогтоох тухай хүсэлтийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлж, 2023 оны зорилтод түвшин батлагдаж ажилчдын цалинг 20-35 хувиар нэмсэн. Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, ажлын тусгай хувцас 7 ширхэг, хамгаалах болон үйлчилгээнд шаардагдах хэрэгсэл материалаар тухай бүр хангаж, мөн 2 компьютер, 4 принтерийг нийт 8,919,4 мянган төгрөгөөр шинээр худалдан авч ажилтныг ажиллах нөхцлөөр хангасан. Шинээр орон байранд орсон 1 ажилтанд 1,000,000.00	100%		

					<p>төгрөг, шинээр хүүхэд мэндэлсэн 1 ажилтанд 500,000.00 төгрөг, 3 ажилтны хүүхдийн сэвлэг үргээх ёслолд 2,000,000.00 төгрөг, 8 ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлтийг үзүүлж 2,560,000.00 төгрөгийг тус тус олгосон.</p>	
3.14	Ажилчдыг мэргэшүүлэх, мэдлэг боловсрол олгох сургалтад хамруулах;	Батлагдсан төсвийн хүрээнд	Сургалтад хармагдсан тоо	1	<p>2023 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд "Алсын хараа"-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, 02 дугаар сарын 16-ны өдөр "Архивын нөхөн бүрдүүлэлт", 03 дугаар сарын 22-ны өдөр Төрөөс стандартчилал хэмжилзүйн талаар баримтлах бодлого, Стандарт ба хөгжил" үндэсний хөтөлбөрийн төсөл, хэлэлцүүлэг, 04 дүгээр сарын 07-ны өдөр "Хүүхдийн хоол" хэлэлцүүлэг, 04 дүгээр сарын 21-ний өдөр "Бизнес процессын дахин загварчлал", 05 дугаар сарын 05-ны өдөр Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлангийн дэд системийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан системд тайлагнах, 05 дугаар сарын 10-ны өдөр Татварын хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил эрсдлээс урьдчилан сэргийлэх, 06 дугаар сарын 06-ны өдөр "Хүүхдийн хоол-хөгжил" үндэсний чуулган, 08 дугаар сарын 01-ний өдөр "Хүнсний ногооны тогтвортой нийлүүлэлт, хүртээмжтэй борлуулалт" сэдэвт зөвлөлдөх уулзалт, 09 дүгээр сарын 29-ний өдөр "Эд хариуцагч", 10 дугаар сарын 04, 09-ний өдрүүдэд "Харилцан суралцах арга зүй", 10 дугаар сарын 21, 22-ны өдөр "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг, стратеги төлөвлөгөө боловсронгуй болгох вакуумжуулсан семинар", 10 дугаар сарын 31-ний өдөр "Байгууллагын сэтгэлзүй болон амьдралын даатгалыг ашиглан амжилтаа урт удаан хугацаанд тогтвортой ажиллуулах", 11 дүгээр сарын 07-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй, имидж бүрдүүлэлт", 11 дүгээр сарын 09-ний өдөр</p>	100%

					<p>"Нийгмийн даатгалын багц хууль", 11 дүгээр сарын 28-ны өдөр "MS Excel" дунд ахисан шат, 12 дугаар сарын 01-ний өдөр "Хүнсний аюулгүй байдлыг хангах", 12 дугаар сарын 04-ний өдөр "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлт гаргах арга зүй", 12 дугаар сарын 08-ны өдөр "Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын оролцоо" зөвлөгөө, 12 дугаар сарын 08-ны өдөр "Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл хөтлөх, архивын баримтын хадгалалт хамгаалалт" гэх мэт 20 сургалтанд нийт 8 ажилтан хамрагдсан.</p>		
3.15	Ажилчдыг нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын хувцас хэрэгслээр хангах, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах;	Батлагдсан төсвийн хүрээнд	Үзлэг, шинжилгээнд хамрагдсан тоо	1	2	2023 оны жилийн эцсийн байдлаар нийт ажилчдыг Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт 2 удаа хамруулахад 1,194,000.00 төгрөг, хавар, намар, өвлийн гуталд 1,250,000.00 төгрөг, хавар, намар, өвлийн куртик, өмдний хос 1,150,000.00 төгрөгийг тус тус зарцуулсан байна.	100%
3.16	Сул ажлын байрны зарыг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулж, сонгон шалгаруулалтыг явуулж байх;	Төсөв шаардахгүй	Сул ажлын байрыг зарласан тоо	2	3	Байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай менежер, хуульч, хүний нөөц-1, эрүүл ахуйч-1, захирлын туслах, кассын нярав-1, түгээлтийн нярав-2, жолооч-1, ачигч-4 сул орон тоог тус бүр байгууллагын bagachuukhuuns.ub.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар зарлаж, нийт 10 ажилтанг сонгон шалгаруулж томилсон.	100%
3.17	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих;	Батлагдсан төсвийн хүрээнд	Нийт тарьсан модны тоо	1	2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Ногоон хот-Иргэний оролцоо" хаврын мод тарих аянд хуваарийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, Баруун салаа, "Бумбатын булаг" гэдэг газар очиж намар тарьсан модны ойр орчмыг цэвэрлэж, нөхөн сэргээлт хийж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Ногоон хот иргэний оролцоо" намрын мод тарих хуваарийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр	100%

							Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо "Инчон мөрөөдлийн төгөл" хотхонд 217 ширхэг шинэс мод тарьж ажилласан.	
ЗОРИЛТ 4. Дүрмээр хүлээсэн үүргийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажил								
4.1	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүнийг чанар, стандартын шаардлагад нийцсэн, шинжилгээнд бүрэн хамрагдсан, эрүүл, аюулгүй, баталгаатай байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдэд нийлүүлэх;	Төсөв шаардахгүй	Чанар стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлэх	100	100	100	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүнийг чанар, стандартын шаардлагад нийцсэн, шинжилгээнд бүрэн хамрагдсан, эрүүл, аюулгүй, баталгаатай байдлыг хангасан эсэхэд өдөр тутам хяналт тавьж Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит 73 цэцэрлэгүүдэд 119 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг захиалгын дагуу нийлүүлэн ажиллалаа.	100%
4.2	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит сургуулиудад чанар, стандартын шаардлагад нийцсэн, шинжилгээнд бүрэн хамрагдсан, эрүүл, аюулгүй, баталгаатай байдлыг хангасан хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	Төсөв шаардахгүй	Хэрэгжилтйн хувь	100	100	100	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит сургуулиудад чанар, стандартын шаардлагад нийцсэн, шинжилгээнд бүрэн хамрагдсан, эрүүл, аюулгүй, баталгаатай байдлыг хангасан 119 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг захиалгын дагуу нийт 13 сургуульд нийлүүлэн ажиллалаа.	100%
4.3	Ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах төлөвлөгөөний дагуу байгууллагын ашигт ажиллагаанаас хамааран ажиллагсдад үр дүнгийн урамшуулал олгох;	Төсөв шаардахгүй	Хэрэгжилтйн хувь	100	100	100	Ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах төлөвлөгөөний дагуу байгууллагын ашигт ажиллагаанаас хамааран ажиллагсдад үр дүнгийн урамшууллыг эхний хагас жилд олгосон ба жилийн эцсийн урамшууллыг олгохоор төлөвлөн ажиллаж байна.	100%
ЗОРИЛТ 5. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд								
5.1	"Цахим улаанбаатар" төсөл, "Digital first" аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулах	Төсөв шаардахгүй	Хэрэгжилтйн хувь	100	100	100	"Цахим улаанбаатар" төсөл, "Digital first" аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

5.2	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллах	Төсөв шаардахгүй	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт хувь	100	100	2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл байхгүй. Нийслэлийн өргөдөл гомдлын цахим еgr.ulaanbaatar.mn программаар ирсэн ажилтны гаргасан 15 өргөдлийг хүлээн авч, ажилд орох 10, жирэмсний болон амаржсаны амралттай 2, хавсран гүйцэтгэсэн ажлаас чөлөөлөх 1, ажлаас чөлөөлөх 2 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100%
5.3	Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах;	Төсөв шаардахгүй	Хэрэгжилтийн хувь	100	100	2023 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 21 багцаас 12 багцад 14 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 9 багцад огт тендерийн материал ирээгүй болно. 12 багцад ирүүлсэн тендерийн баримт бичгийг үнэлж үзээд 5 аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулах эрх олгож гэрээг байгуулан ажиллаж байна. 16 ажлаас төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудсаар 2 дахь тендэрийг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зарласан ба 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр тендерийн нээлт хийж, нийт 16 багц шалгаруулахаас тендерийн материал ирүүлсэн 5 багцад хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн хонь, үхрийн маханд "Хулагу холдинг" ХХК, нарийн бүдүүн ногоонд "Эрдэнэ энх" ХХК, цагаан идээнд "Ану-Нинж" ХХК нь хамгийн сайн тендерээр үнэлэгдэн шалгарсан. Шалгараагүй 11 багцад шууд гэрээ байгуулан ажиллахыг үнэлгээний хорооноос зөвлөмжөөр хүргүүлсний дагуу шууд гэрээ байгуулан, мөн түргэн гэмтэх бүтээгдэхүүн болох сүү сүүн бүтээгдэхүүнийг худалдах худалдан авах гэрээний дагуу "Апу дейри" ХХК-аас шууд түгээлгэж, талх, талхан бүтээгдэхүүнийг "Талх чихэр" ХХК-тай хийсэн гурвалсан гэрээний дагуу үйлдвэрээс шууд түгээлгэн, хөндлөнгийн хяналтыг хийн ажиллаж байна.	100%

5.4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд оруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;	Төсөв шаардахгүй	Хувь	100	100	Хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн аж ахуйн нэгжтэй бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулж, хуулийн хугацаанд tender.gov.mn-д байршуулж, шилэн дансанд шаардлагатай бүх мэдээллийг хугацаанд нь байршуулж ажилласан.	100%
5.5	Байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан иргэд олон нийтэд ил тод мэдээлж ажиллах;	Төсөв шаардахгүй	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын цахим хаяг Bagachuuhuns.ub.gov.mn болон байгууллагын мэдээллийн самбарт санхүү, хүний нөөц, ажлын зар, дүрэм журам, сургалтын мэдээлэл, шинэ мэдээлэл, үйл явцыг тухай бүр нь оруулан ажиллаж байна.	100%
5.6	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах	Төсөв шаардахгүй	Сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн тоо	100	100	2023 оны жилийн эцсийн байдлаар сэтгэл ханамжийн судалгааг 4 удаа зохион байгуулж, судалгааны дүгнэлтэнд үндэслэн ажиллаж байна.	100%

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

2023 оны ..... сарын ..... өдөр

ТАЙЛАГНАСАН:

БАГАЧУУД ХҮНС ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

2023 оны ..... сарын ..... өдөр

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ:

Х.НЯМБААТАР

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Б.МӨНХНАСАН

